

МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН НЭН ТЭРГҮҮН ЗОРИЛТ БОЛОХ ЯДУУРАЛТАЙ ХЭРХЭН ТЭМЦЭЖ БАЙНА ВЭ?

Л.Цэцгээ¹

Дэлхий дээр тулгараад байгаа хамгийн том бэрхшээлийн нэг нь ядуурлын гамшиг юм. Өнөөдөр дэлхий дээр 1,4 тэрбум орчим хүн туйлын ядуу амьдарч байна. Дэлхий дээр амьдарч буй ядуу хүмүүсийн 70% -ийг эмэгтэйчүүд эзэлж байна (дэлхийн банкны тайлан).

Мянганы хөгжлийн нэн тэргүүний зорилт нь туйлын ядуу байдал, өлсгөлөнг арилгах явдал бөгөөд энэ зорилтыг хэрэгжүүлэхэд гол хүч нь Дэлхийн банк болоод байна.

Дэлхийн банкны үйд ажиллагааны гол зорилго нь өнөөдөр дэлхийн 100 гаруй оронд амьдарч байгаа өдрийн орлого нь 1,25 ам. доллараас бага 1,4 тэрбум хүн, өдрийн орлого нь 2 ам. доллараас бага байгаа 2,6 тэрбум хүний төлөө чиглэгдэж байгаа ажээ (econ.worldbank.org/programs /poverty/). Дэлхийн банкнаас боловсруулсан ядууралтай тэмцэх стратегид дараах зүйлийг багтааж байна. Үүнд:

- эдийн засгийн хэлбэлзлийг даван гарах нөхцлөөр хангах
- орлого багатай өрхөд үндсэн үйлчилгээг хүргэх замаар эдийн засгийн өсөлтийн ашгаас хүртэх боломжийг олгох
- нийгмийн хамгааллыг хүргэх
- дэд бүтэц болон бусад үйлдвэрлэлийн ашгийг нэмэгдүүлэх
- тайлагнагч, илүү ил тод байгууллагуудыг бий болгох зэрэг юм.

Эдгээрийг биелүүлэхэд гол нөхцөл нь нийгмийн бүх давхаргын эрх ашигт нийцсэн эдийн засгийн өсөлтийг хурдасгах явдал мөн гэжээ.²

1996 оноос эхлэн Австралийн Засгийн газар дэлхий даяар ядуурлыг бууруулах үйлст амжилттай оролцож байгаа бөгөөд энэ хөтөлбөр 2010 онд 3.8 тэрбум ам. долларыг Африк болон Ази, Номхон далайн орнуудын ядуурлыг бууруулахад зориулах юм байна.

Австралийн Засгийн газрын хилийн чанадад туслах хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид сүүлийн жилүүдэд ядуурал гэдэг ойлголт олон талт ойлголт боллоо гээд ядуурал нь орлого хэрэглээний хэмжээст тулгуурласан ойлголтоос нийгэм, хүрээлэн байгаа орчин, өртөмтгий байдал тэр ч бүү хэл жендерийн асуудлаар тодорхойлогдох ойлголт гэж үзэж байна.

Ядуу хүмүүст хамааралтай шийдвэрийг гаргах явцад тэднийг өөрсдийг нь оролцуулдаггүй үлдээдэг байна. Ядуу хүмүүс байгалийн гамшиг, өвчин, иргэний зөрчилдөөн зэрэг гэнэтийн хүчтэй цочролд хамгийн өртөмтгий хүмүүс юм гэж энэ хөтөлбөрийнхөн үзэж байна.

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш, докторант

² Alejandra Viveros econ.worldbank.org/programs/poverty

Австралийн Засгийн газрын ядууралтай тэмцэх хөтөлбөрийн стратеги нь дараах дөрвөн тулгууртай байна гэжээ. Үүнд:

Ядууст үр өгөөжтэй, байнгын өсөн нэмэгдэж буй эдийн засгийн өсөлт бий болгох үйл ажиллагааг бэхжүүлэх ;

- Инфляци болон өр зээлийг өндөр түвшинд хүрэхээс сэргийлэх макро эдийн засгийн эрүүл бодлогыг бүрдүүлэх
- Ядууст өгөөж бүхий байнгын өсөн нэмэгдэж буй засгийн газрын бодлогыг дэмжих (татварын тогтолцоо нь нийцэлтэй бодит байх);
- Зах зээлийн чөлөөт байдал болон чөлөөт худалдааг хөгжиж буй орнуудад өгөөжтэй байлгах;
- Нийгмийн ядуусын хэрэгцээг онцгойлон анхаарч үзсэн эдийн засгийн дэд бүтцээр хангах, төрийн хууль журам сайн байх нь эдийн засгийн өсөлтийн нэг гол нөхцөл юм.

Ядуусын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэх

- Газар эзэмшүүлэх, зээл олгох;
- Эрүүл мэндийг нь хамгаалах, сургалт явуулах, хүний нөөцөд нь хөрөнгө оруулах;
- Эмэгтэйчүүдийн нийгмийн хөгжилд оролцох оролцоог болон нийгмийн хөгжлийн ашиг шимээс хүртэх боломж олгосон үр ашгийг дэмжих;
- Хүүхдийг ядуурлаас гарахад чиглэсэн хөтөлбөрийг цаашид дэмжих, ийм хөтөлбөрт хөрөнгө оруулах.

Засгийн газар, байгууллагууд болон донор орноос үзүүлж буй тусламж нийтэд ил тод байх

- Засгийн газраас явуулж буй үйл ажиллагаанд ядуусын оролцоог нэмэгдүүлэх;
- Иргэний нийгэмлэг болон Засгийн газраас ядуусын оролцоог дэмжихэд саад болж буй хүчин зүйлсийг арилгах, ядуусыг бүр шийдвэр гаргах түвшинд оролцуулах;
- Хууль эрх, хүний эрх, ардчилсан байгууллагуудыг бэхжүүлэх, иргэний нийгэмлэгүүдийг бий болгох;
- Удирдлагыг илүү бүтээлч, үр дүнтэй, илүү ил тод болгох;
- Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст илүү анхаарч энэ талаар явуулж буй үйл ажиллагааг дэмжих

Өртөмтгий байдлыг багасгах

- Маргалдаан зөрчилдөөн гарах аливаа байдлыг багасгах үйл ажиллагаа болон арга замыг дэмжих;
- Ядуусыг ялгаварласан нийгмийн аливаа дэглэм журамтай тэмцэх;
- Хүнд хөнөөлтэй болон байгалийн гамшгийг бууруулах аливаа хөтөлбөрт хөрөнгө оруулах;
- Гамшгийн золиос бологсдод Засгийн газраас хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг судлах;
- Аливаа эрсдэл тохиолдоход нийгмээс үзүүлэх цогц механизмыг бий болгох.

Ядуурлыг бууруулах Австралийн тусламжийн хөтөлбөр нь одоогийн байдлаар Ази, Номхон далайн орнуудын хүн амын ядуурлын түвшинг 2015 он гэхэд 12% болгож бууруулах тооцоотой байна.

1998 оны байдлаар дэлхийн үгээгүй ядуусын 2/3 нь Ази болон Номхон Далайд амьдардаг гэсэн судалгаа гарчээ. Австралийн засгийн газраас хэрэгжүүлж буй ядуурлыг бууруулах хөтөлбөр нь эдгээр хүмүүст голлон чиглэж байна. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид ядуурлыг бууруулах хамгийн гол хүч нь эдийн засгийн өсөлт гэж үзэж байна. Эдийн засгийн өсөлтийн сүүлийн 20 жил дотор Энэтхэгт ядуурлын түвшин 4 дахин буурсан ба нэн ялангуяа орлогын тэгш бус байдал багассанаар ядуурлыг бууруулах хэмжээ төдий чинээ өсдөг байна. Ядуурлыг бууруулах эдийн засгийн өсөлтөд дараах хүчин зүйлүүдийг хамгийн чухалд тооцдог байна.

- Зах зээлийг чөлөөлөх;
- Засгийн газрын хариуцлагыг дээшлүүлэх;
- Санхүүгийн болон хуулийн системийг эрүүлжүүлэн сайжруулах;
- Инфляцийг нэмэгдүүлэхгүй байх бодлого явуулах;
- Эдийн засгийг хэлбэлзэлгүй байнгын өсөлттэй түвшинд барих;
- Боловсрол олгох болон эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломжийг нэмэглүүлж, хүний нөөцөд хөрөнгө оруулалт хийх;
- Орлогын эх үүсвэр болсон ажлын байрыг нэмэгдүүлэх;
- Ядуучуудад ажлын байр, орлого бий болгогч хувийн секторын хөгжилд дөхөмтэй нөхцлийг бүрдүүлэх;
- Ядуу хүмүүсийн орлого олох боломжийг нэмэгдүүлэн, эмзэг бүлгийнхэн болоод эмэгтэйчүүдийг орлогын эх үүсвэртэй болгох;
- Хөдөө аж ахуйн секторын бүтээмжийг нэмэгдүүлэх;
- Сайн удирдлагын гол хүчин болсон санхүүгийн менежментийг сайжруулах, хууль шудрага ёсыг бэхжүүлэх, улсын секторын бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэний хөдөлгөөнийг бий болгох;
- Боловсролын салбарт явуулах үйл ажиллагаа нь боловсрол эзэмшихэд жендерийн тэнцвэрийн байдлыг тооцож үзэн, охид эмэгтэйчүүдэд боловсрол эзэмшүүлэхэд онцгой анхаарах;
- Эрүүл мэндийн үйлчилгээг ядуучуудад ойртуулах, тэдэнд хүртээмжтэй болгох;
- Эрүүл ахуйн шаардлага хангасан амьдрах орчин бүрдүүлэх;
- Ундны цэвэр усаар хангах;
- Тэжээллэг хүнсээр хангах;
- Орон нутаг зах хязгаарыг хөгжүүлэх;
- Хүнсний аюулгүй байдлыг хангах;
- Зам харилцааг хөгжүүлэх ;
- Жендерийн бодлого зэрэг юм.

Нэвтэрхий толь Wikipedia-д өгүүлснээр ядуурлыг бууруулахад эдийн засгийн чөлөөт байдал, гол стратегиуд нь дараах зүйлс байна хэмээн дурджээ:

Ядуучуудын өмчтэй байх эрхийг хамгаалах.

Ядуучуудад газар эзэмшүүлэхэд тэднийг баялагтай ба зарим тохиолдолд 2 дахин их баялагтай болгодог гэсэн дүгнэлтийг дэлхийн банкнаас гаргасан байна.

Сүүлийн арван жилд /decade/ Хятад болон Энэтхэг улсад хамтралын аж ахуйг халж хүмүүст газрыг олгосноор ядуурал буурсныг тэмдэглэжээ.

Хүнд суртлыг арилгах нь ядуурлыг бууруулах нэг хүчин зүйл болдог. Жишээ нь:

Канадад 280 \$ төлөөд шинэ бизнес эхэлж болдог бол Боливт 2696\$ төлж, хүнд суртлын 20 ажиллагааг дамжиж ажлын 82 хоногт хүлээж байж шинэ бизнес эхэлдэг ажээ

Бусад хүчин зүйлээс дурдвал:

- капиталыг өсгөх, дэд бүтэц технологийг хөгжүүлэх;
- тусламж, нийгмийн хангамжийг сайжруулах;
- ядуу иргэдэд боловсрол эзэмшүүлэх, мэрэгжил олгох;
- ядууст бичил зээл олгох;
- авилгалтай тэмцэх;
- хуулийг биелүүлэх, дагаж мөрдөх;
- цаг агаарын өөрчлөлтөд зохицох арга хэмжээ авах;
- гэр бүл дэх эмэгтэйчүүдийн үүргийг нэмэгдүүлж, гэр бүл төлөвлөлтийн зөвлөлгөө өгөх;
- үндэсний мөнгөн тэмдэгтээ дээдлэх зэрэг бусад хандлагууд юм.

Бусад орны ядуурлыг бууруулж буй туршлагаас дурьдвал: 2009 оны 5 дугаар сарын 5 -нд АНУ –н Төрийн бодлогын институтээс гаргасан Ядуурлыг бууруулах цогц бодлого илтгэлдээ эрүүлийг хамгаалах систем болон эрүүл мэндийн даатгалын системийг эрс шинэчлэхгүйгээр ядуурлыг бууруулах ямар ч стратеги хэрэгжихгүй гэж дүгнэжээ. Энэ илтгэлд Дэвид Р.Ирмер хүүхдүүдийн дундах ядуурлыг бууруулах өөр нэгэн чухал стратеги нь хүүхдийн эрүүл мэндийг хамгаалж, боловсрол олгох явцыг мэдэгдэхүйц сайжруулснаар тэд хэзээ ч ядууралд орохгүй гэж дүгнэжээ.

Германд амьдралын өртгийг дарж хүрэхүйц хэмжээний цалингийн доод хэмжээг улсаас тогтоох нь ядуурлыг бууруулах гол гарц гэж үзэж байна. Мөн цэцэрлэг сургуулийн өдөр өнжүүлэх ангийн цагийг уртасгах, өрх толгойлсон эхчүүдийн ажиллах цагийг уртасгах, нийгмийн гол ачааг үүрч байгаа дундаж давхаргынханд илүү анхаарах явдал гэжээ.³

Их Британи нийгмийн тэтгэлэг авч буй хүмүүсийг ажлын байраар хангах, өрхийн санхүүгийн баталгаат байдлыг сайжруулах, эмзэг бүлгийнхэнд илүү их анхаарал тавих стратегийг баримталж байгаа ба нийгмийн хамгааллын бодлого болон татварын системд шинэчлэлт хийж бага орлоготой өрхүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын баталгааг хангах арга хэмжээнүүдийг авч байгаа ажээ. Сүүлийн жилүүдэд боловсрол, эрүүл мэнд, ажлын байрыг нэмэгдүүлэх болон орон сууцаар хангах арга хэмжээнд засгийн газраас их анхаарч хөрөнгө зарж байгаа юм байна.

Бразил улс санхүү эдийн засгаа тогтворжуулж зээлийг нэмэгдүүлснээр орлогыг ард түмэндээ тэнцүү хүртээж чадна гэж үзэж байгаа бөгөөд эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын системийн үйл ажиллагаанд төрийн оролцоог нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг ханган, инфляцыг бууруулж, орлого багатай өрхийн татварын дарамтыг бууруулах явцыг үргэлжлүүлснээр 2016 он гэхэд туйлын ядуурлыг арилгаж чадна гэжээ⁴

Латин Америкийн орнуудын хувьд эдийн засгийн өсөлт нь ядуурлыг бууруулах гол нөхцөл гэж үзэж байгаа боловч ард түмний эрүүл мэндийг анхаарч сайжруулах, хүүхэд, насанд хүрэгчдийн боловсролд анхаарах, дэд бүтцийг хөгжүүлэх, өрхийн орлогын ялгааг багасгах зэрэг бодлого баримталж байгаа ба нэн тэргүүний ач холболгдол нь ард түмнийг боловсролтой болгох

³ улс төрийн тоймч Михаил Стеновик Braunschweiger Zeitung, Berliner Morgenpost newspapers

⁴ Рио-Де-Жанейро, 12 янв-РИА Новости, Александр Краснов

явдал гэж үзэж байна.⁵

Дүгнэлт

Өнөөдөр дэлхийн хүн амын бараг тал хувь нь ядуу болон нэн ядуу амьдарч байгаа юм байна. Ядуурлын түвшин нь өөр өөр боловч орон бүрт бодитойгоор оршиж буй бэрхшээл бөгөөд ядууралтай тэмцэх стратеги нь тухайн орныхоо нийгмийн хөгжил эдийн засгийн төвшингөөс шалтгаалан ялгаатай байгаа нь харагдлаа Жишээлбэл Их Британид өрхийн санхүүгийн баталгаат байдлыг нэмэгдүүлэх бодлого барьж байхад Латин Америкийн болон азийн орнуудад ард иргэддээ боловсрол эзэмшүүлэх асуудлыг голлон анхаарч байгаа юм байна.

Ядуурлыг бууруулах бодлогод авилгал хээл халуультай тэмцэх, орлого багатай иргэдээс авах татварыг багасгах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх, иргэдийнхээ эрүүл мэндэд бага наснаас нь анхаарч хүүхдийг эрүүл өсгөхөд Засгийн газраас анхаарах мөн боловсрол олгох явдал нь ядууралд орохгүй байх нөхцлийг хангана гэж үздэг байна. Мөн өрх толгойлсон эхчүүдийн ажиллах цагийг нэмэгдүүлэх боломж олгохын тулд хүүхдийг нь өдөр өнжөөх ангид харах цагийг сунгах арга хэмжээ авдаг зэрэг нь авууштай санагдлаа.

Эрүүл бөгөөд боловсролтой иргэнтэй улс оронд ядуурлын түвшин доогуур байна гэдэгтэй санал нэг байна.

Ашигласан материал

www.adb.org/...Strategies/default.asp

<http://www.zmag.org/sustainers/content/2006-09/28parenti.cfm>

en.wikipedia.org/.../Poverty_reduction

en.wikipedia.org/.../Poverty_reduction

www.heritage.org/.../Understanding-and-Reducing-Poverty-in-America

[www.iadb.org/.../trade-liberalization-contributed-to-reduce-poverty-in-latin-america-idb-book-](http://www.iadb.org/.../trade-liberalization-contributed-to-reduce-poverty-in-latin-america-idb-book-2020)
2020 Focus Brief on the World's Poor and Hungry People

Ссылка: UNEP/NSDS/March 2006

www.iadb.org/.../trade-liberalization-contributed-to-reduce-poverty-in-latin-america-idb-book-
Packaging Policies to Reduce Poverty., David .R. Riemer, director of Policy and Planning Community
Advocates Public Policy Institute

www.usaid.gov.au/.../default.cfm

⁵ *Economic reform to stimulate growth and reduce poverty, Latin American experience, Albert Valdes and William Foster, Oct 2007*